

**"УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ
САНХҮҮЖҮҮЛЭХ ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТУХАЙ" МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААР
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ
САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай
хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн
хураалгасан, Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

1.Тогтоолын төслийн нэрийн "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар" гэснийг "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний талаар" гэж, төслийн 1 дэх заалтын "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар" гэснийг "Улс, орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалт /цаашид "төсвийн хөрөнгө оруулалт" гэх/-аар" гэж тус тус өөрчилж, төслийн тэмдэглэх хэсгийн "Хууль тогтоомжийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.4, 25.5 дахь хэсэг," гэснийг тус тус хасах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар

2.Тогтоолын төслийн 1.1 дэх дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"1/төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж эхэлсэн боловч бүрэн дуусаагүй зогссон төсөл, арга хэмжээний ашиглалтад ороогүй шалтгаан, төсөвт үзүүлж байгаа үр дагавар, нөлөөллийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр судалж, холбогдох тайлан болон цаашид төсвийн хөрөнгө оруулалтаар үргэлжлүүлэх, эсхүл өмчлөлийн өөр хэлбэрт шилжүүлэх зэрэг асуудлаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналаа 2026 оны 09 дүгээр сарын 15-ны дотор Улсын Их Хуралд танилцуулах;"

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар

3.Тогтоолын төслийн 1 дэх заалтын "хэрэгжүүлж байгаа" гэсний өмнө "болон Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрээр" гэж нэмж, төслийн 1.2 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"2/Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлж эхэлсэн боловч зээлийн хэлэлцээрийн хугацаанд бүрэн дуусах боломжгүй зогссон төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг энэ тогтоолын 1.1-д заасан тайланд тусгах."

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар